

БАТЛАВ.
УЛААНБААТАР ЦАХИЛГААН
ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Р.ДАГДАН

АУДИТЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2021 оны 01 дүгээр
сарын 27-ны өдөр

БАТЛАВ.
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



О.ТЭНГИС

Дугаар 417/АА 276

Улаанбаатар хот

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Энэхүү Аудитын ажил гүйцэтгүүлэх гэрээ /цаашид “Гэрээ” гэх/-г Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.6 дахь хэсэг, Аудитын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид үндэслэн нэг талаас Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК /цаашид “Шалгагдагч этгээд” гэх/, түүнийг төлөөлж Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч О.Ариунболд, нөгөө талаас Үндэсний аудитын газар, түүнийг төлөөлж Аудитын хоёрдугаар газрын захирал, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг /цаашид “Гүйцэтгэгч”/ нар дараах нөхцөлийг харилцан тохиролцож байгуулав.
- 1.2. Гүйцэтгэгч нь Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргах, Шалгагдагч этгээд нь аудитын тайланг хүлээн авч гэрээгээр тохиролцсон аудитын үйлчилгээний хөлс төлөх үүргийг тус тус хүлээнэ.
- 1.3. Талууд Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгон гэрээний үүргээ хугацаанд нь, зохих ёсоор, шударгаар биелүүлнэ.

ХОЁР. ТОДОРХОЙЛОЛТ

- 2.1. Энэхүү гэрээнд заасан нэр томъёонуудыг Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн дор дурдсан утгаар ойлгоно:
 - 2.1.1. “Шалгагдагч этгээд” гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулж буй Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийг,
 - 2.1.2. “Гүйцэтгэгч” гэж Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь хэсэгт заасны дагуу “санхүүгийн тайлангийн аудит” гэж шалгагдагч этгээд санхүүгийн тайлангаа холбогдох хууль тогтоомж, стандарт, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн актын шаардлагад нийцүүлэн үнэн зөв, шударгаар тайлагнасан эсэхэд аудит хийж баталгаажуулах” Үндэсний аудитын газрыг,
 - 2.1.3. “Гэрээгээр тохиролцсон ажил” гэж энэхүү гэрээнд заасны дагуу Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийж дүгнэлт гаргах, баталгаажуулах үйл ажиллагааг;
 - 2.1.4. “Аудитын үйлчилгээний хөлс” гэж Гүйцэтгэгчээс Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасны төлөө Шалгагдагч этгээдээс төлөх төлбөрийг.

ГУРАВ. ГЭРЭЭГЭЭР ТОХИРОЛЦСОН АЖИЛ

- 3.1. Гүйцэтгэгч нь Шалгагдагч этгээдийн хүсэлтээр Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргана.

ДӨРӨВ. АУДИТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС

- 4.1. Сангийн сайдын 2018 оны 251 дүгээр тушаалаар батлагдсан Аудитын үйлчилгээний хөлсний хэмжээ, жишгийг үндэслэн аудитын үйлчилгээний хөлсийг 48.5 /Дөчин найман сая таван зуун мянга/ сая төгрөгөөр тогтоосон байна.
- 4.2. Шалгагдагч этгээд нь гэрээ байгуулагдсанаас хойш ажлын 5 өдрийн дотор энэхүү гэрээний 4.1-т заасан аудитын үйлчилгээний төлбөрийн 100 хувь Гүйцэтгэгчид урьдчилан төлнө.
- 4.3. Шалгагдагч этгээд нь аудитын үйлчилгээний төлбөрийг Гүйцэтгэгчээс ирүүлсэн албан ёсны нэхэмжлэхэд үндэслэн, түүний нэрлэсэн дансанд шилжүүлнэ.

ТАВ. ШАЛГАГДАГЧ ЭТГЭЭДИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 5.1. Шалгагдагч этгээд нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:
 - 5.1.1. Аудитад шаардлагатай мэдээлэл, баримт материалыг өөрийн ажлын байранд гарган өгнө;
 - 5.1.2. Сангийн сайдын 2018 оны 251 дугаар тушаалаар батлагдсан Аудитын үйлчилгээний хөлсний хэмжээ, жишгийг үндэслэн аудитын үйлчилгээний төлбөрийн тогтоосон хэмжээнд санал өгнө;
 - 5.1.3. Аудитын үйлчилгээний төлбөрийг Үндэсний аудитын газрын төрийн сан банк 100900024401 тоот дансанд гэрээнд заасан хугацаанд төлнө;
 - 5.1.4. Төрийн аудитын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан эрх үүрэг.

ЗУРГАА. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 6.1. Гүйцэтгэгч дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:
 - 6.1.1. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг аудитор бүр гаргах, мөн 9 дүгээр зүйлд заасан албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдал үүсвэл эрх бүхий албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх;
 - 6.1.2. Аудит хийхэд шаардагдах мэдээлэл, судалгаа, тайлбар, тодруулга холбогдох бусад баримт бичгийг бүрэн хэмжээгээр, чөлөөтэй, шуурхай, үнэ төлбөргүй гаргуулан авах;
 - 6.1.3. Энэхүү гэрээнд тусгагдсан ажлыг заасан хугацаанд чанарын ба мэргэжлийн зохих түвшинд хийж гүйцэтгэх;
 - 6.1.4. Аудитыг хийхдээ Төрийн аудитын тухай хууль, Аудитын тухай хууль болон бусад хууль тогтоомж, Аудитын олон улсын стандарт, СТОУС,

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/124 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам”, гэрээгээр аудит хийлгэх холбогдох бусад дүрэм, журмыг баримтлах;

- 6.1.5. Аудитын үйл ажиллагаатай холбоотой төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээллийг задруулахгүй байх;

ДОЛОО. ГЭРЭЭНИЙ БОЛОН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА

- 7.1. Энэ гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдгээр баталгаажуулсан өдрөөс хүчин төгөлдөр болж, гэрээ цуцлагдсанаар, эсхүл талууд гэрээнд заасан үүргээ бүрэн биелүүлж, ажил хүлээлцэх акт үйлдсэнээр буюу 2021 оны 4 дүгээр сарын 01-ны өдөр дуусвар болно.
- 7.2. Аудит хийлгэж байгаа газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын тайлан дүгнэлтийг 2021 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн дотор шалгагдагч этгээдэд хүргүүлнэ.

НАЙМ. БУСАД ЗҮЙЛ

- 8.1. Талууд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба ийнхүү оруулсан нэмэлт, өөрчлөлт нь бичгээр үйлдэж, талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга, тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 8.2. Гэрээг хэрэгжүүлэх явцад үүсэх аливаа маргааныг талуудын эрх бүхий төлөөлөгчид хамтран хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 8.3. Талууд маргааныг харилцан тохиролцож шийдвэрлэж чадаагүй бол шүүхэд хандаж шийдвэрлэнэ.
- 8.4. Гэрээг 3 хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгалсан нь хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Байгууллагын нэр:

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК

Албан тушаал:

Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч

Овог нэр:

О.Ариунболд

Гарын үсэг:

.....

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Байгууллагын нэр:

Үндэсний аудитын газар

Албан тушаал:

Аудитын хоёрдугаар газрын захирал, Тэргүүлэх аудитор

Овог нэр:

Ц.Наранчимэг

Гарын үсэг:

.....